

## ИХ ЮАНЬ УЛСЫН ХЯТАД ДАХЬ НОЁРХЛОО СЭРГЭЭХ ОРОЛДЛОГО

Д.ИДЭР

**Товч агуулга:** 1260 онд Хубилай Их Монгол улсын хаан ширээг залгамжилж, улмаар Хятадыг эрхшээн захирснаар Их Юань хэмээх Их Монгол улс хүчирхэгжин мандсан билээ. 1368 онд Их Юань улсын Хятад дахь засаглал, ноёрхол унаснаар Монголын төр уугуул эх нутагтаа шахагдан гарсан юм. Монгол орондоо буцсан Их Юань улсын хаан, түүний залгамжлагчид Хятад дахь засаглал, ноёрхлоо дахин сэргээн байгуулахыг оролдож, идэвхтэй бодлого, үйл ажиллагааг явуулжээ. Ухаан хаан Тогоонтөмөр 1368-1370 он, Билэгт хаан Аюушидар 1370-1378 он, Усхал хаан Төгстөмөр 1378-1388 оныг хүртэл Монголын төр улсыг удирдан жолоодоходоо дайн самууны улмаас бутран сарнисан төр улсаа эмхлэн цэгцлэх, цэргийн хүчээ нэгтгэн зузаатгах, Мин улсын цэргийн довтолгоог хориглон зогсоох, хараат улс оронтой харилцаа холбоогоо дахин сэргээх, хамтын хүчээр Мин улсыг эсэргүүцэн байлдах, Хятад дахь засаглал, ноёрхлоо дахин сэргээн байгуулахыг зорьж, 20 орчим жил шаргуу тэмцсэн байна. Гэвч Их Юань улсын Хятад дахь засаглал, ноёрхлыг дахин сэргээн байгуулах зорилгодоо хүрч чадаагүй юм. Хэдий тийм боловч эдгээр хаадын бодлого, үйл ажиллагаа нь зарим талаар ихээхэн амжилт олжээ. Тухайлбал, Монголын төр улсыг богино хугацаанд эмхлэн цэгцэлж, цэргийн хүчээ зузаатгасан, 1372 онд Мин улсын их цэргийг бут цохиж, дайсны цэргийг довтолгоог зогсоосон, 1374 онд Мин улс урьд олзолсон хунтайж Майдарбалыг суллан буцааж, найрсаг харилцаа тогтоож байгаагаа илэрхийлсэн, 1374 оноос урьдын хараат улс болох Солонгосын Корйө улстай харилцаагаа дахин сэргээсэн зэргийг дурдаж болно.

**Түлхүүр үг:** Их Юань улс, Мин улс, Ухаант хаан Тогоонтөмөр, Билэгт хаан Аюушидар, Усхал хаан Төгстөмөр, Хаанбалгас хот, Шанду хот, Хархорум хот

**Нэг. Ухаант хаан Тогоонтөмөр Инчан хотыг түшсэн нь.** Ухаант хаан Тогоонтөмөр хаан бол Их Юань улсын Хутагт хаан Хүсэлийн ахмад хөвгүүн юм. Түүний эх нь Харлууд овгийн Майлайди хатан билээ. 1320 онд Алтай уулын баруун талд орших Жоу ван Хүсэлийн аяны өргөөнд Тогоонтөмөр хаан мэндэлжээ. 1329 онд Тугтөмөр хаан ширээнд суусны дараа Тогоонтөмөрийг Хутагт хааны хөвгүүн биш гэсэн цуурхал дэгдээн, хилсээр гүтгэн Корйө улсын

Дачин аралд нутаг заан суулгаж, гаднах хүмүүстэй уулзахыг цаазлан хориглосон байна. 1332 онд Тугтөмөр хааны зарлигаар Тогоонтөмөрийг Гуаньси-гийн Жижян чөлгөөд шилжүүлэн суулгав. Энэ үед Тугтөмөр хааны өвчин үгдэрч хүндэрсэн тул их хатан Будашир, Төвлөн засаглах газрын баруун гарын харилцан туслагч сайд Элтөмөр нарыг дуудан ирүүлээд хаан ширээг Хутагт хааны ахмад хөвгүүн Тогоонтөмөрт гэрээслэн үлдээжээ. Ийнхүү Тогоонтөмөр 1333 онд хаан ширээнд өргөмжлөгдсөн билээ.

Их Юань улсын түүхэнд хамгийн олон жил хаан ширээнд сууж, төр улсыг удирдан жолоодсон хаан бол Тогоонтөмөр хаан юм. Тэрээр 1333 оноос 1370 оныг хүртэл 37 жил хаан ширээнд суужээ. Түүнийг хятад сурвалж бичигт “Цагаан бичин хаан” хэмээн нэрлэсэн байдаг. Энэ нь Янюү-гийн долоодугаар он буюу 1320 он бол цагаан бичин жил болно. Тиймээс Тогоонтөмөр хааны төрсөн жилээр нэрлэжээ. Тогоонтөмөр хааны тахилын сүмийн цолыг “Хуйзун (惠宗-hui zong)” гэдэг. Үүнийг монголоор орчуулбал “Ухаант хаан” гэсэн утгыг илэрхийлнэ.<sup>1</sup> Ийм учраас монгол сурвалж бичгүүдэд Тогоонтөмөр хааныг Ухаант хаан хэмээн бичдэг. Мин улсын хаан Жү Юаньжан Их Юань улсын Тогоонтөмөр хааныг “*Тэнгэрийн зарлигийг дагаж байлдалгүй ухран одсон*” явдлыг онцгойлон сайшаан “Шүньди (順帝-shun di) хэмээх цолоор нэхэмжлэн өргөмжилжээ.<sup>2</sup> Энэхүү Шүньди гэдэг цол нь Эет хаан гэсэн утгыг илэрхийлнэ. Хятад сурвалж бичигт Тогоонтөмөр хааныг “Шүньди хаан” хэмээн бичих ажээ.

1368 оны илүү долоон сард Тогоонтөмөр хаан их нийслэл Хаанбалгас хотоо орхин Шанду хот руу явжээ. Хааныг дагалдан гурван ордны хатад, сул хатад, хунтайж, түүний сул хатад болон Төвлөн засаглах газрын зүүн гарын харилцан туслагч сайд Ширмэн, улсын хэргийг тэгшитгэн шийтгэгч сайд Зан Жяну, баруун гарын туслагч сайд Динжү, улсын хэргийг оролцон мэдэгч сайд Хахай, Бичгийн мэргэдийн хүрээлэнгийн зарлигч түшмэл Ли Бай Жяну, Цэргийн явдлын хүрээлэнгийн хэрэг мэдэгч түшмэл Харажан, Ван Хунюань зэргийн зуу гаруй хүмүүс явжээ.<sup>3</sup>

Удалгүй Тогоонтөмөр хааны хөсөг тэрэг Цавчаал боомтод хүрэв. Энэ үед улаан алчууртны хулгай дайран өнгөрсөн учир эмх замбараагүй, зам чөлгөө эл хуль болоод боомтод нэг ч цэрэг харагдсангүй. Хөсөг тэрэг морилон ирэхэд хангамж ч байсангүй. Тогоонтөмөр хаан санаа алдан өгүүлсэн нь “*Миний бие нийслэл хотоос гараагүй учир гаднах хэрэг энэ мэт болсныг хэрхэн мэдэх билээ?*”<sup>4</sup> хэмээв. Ингээд Тогоонтөмөр хаан Есү жанжныг өөрийн харьяат цэргийг дагуулан түргэн явж байрлахыг зарлигдсан байна.

<sup>1</sup> Түжи. *Монголын түүхэн тэмдэглэл*. Дэд дэвтэр. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 2011. т. 937-938

<sup>2</sup> 《北平录》，薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》第一辑，内蒙古大学出版社，2000年，第9页。

<sup>3</sup> 刘佶：《北巡私记》，薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》第一辑，内蒙古大学出版社，2000年，第2页。

<sup>4</sup> 刘佶：《北巡私记》，薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》第一辑，内蒙古大学出版社，2000年，第2页。

Хааны хөсөг тэрэг Жимин шань уулыг дайран Ин коу амд хүрч иржээ. Цэргийн явдлын хүрээлэнгийн хэрэг мэдэгч түшмэл Харажан Тогоонтөмөр хаанд бараалхан Хөхтөмөр жанжныг туслахаар яаралтай дуудан ирүүлэхийг хүсэв. Хаан түүний хүсэлтийг зөвшөөрчээ. Энэ үед Бичгийн мэргэдийн хүрээлэнгийн зарлигч түшмэл Гуань Иньнү хүрч ирэв. Мөн Ляодун төлөөний мужийн улсын хэргийг оролцон мэдэгч сайд Сайнтөмөр таван мянган морьт цэргээ дагуулан хүрч ирэн цэргийн хүчийг нэмэгдүүлжээ.

Мин улсын их цэрэг Их Юань улсын их нийслэл Хаанбалгас хотыг байлдан эзлэв. Их нийслэл хотоо хамгаалж байсан Хуай ван Төмөрбуха, харилцан туслагч сайд Чинтун, Дайду чөлгөөгийн ерөнхий захирагч Куо Юньжун, Төвлөн засаглах газрын зүүн гарын харилцан туслагч сайд Дин Жинкэ нар цөмөөр тулалдаж алагдав.<sup>5</sup>

Их Юань улс Жунюань орон дахь газар нутгаа бүгдийг нь Мин улсад алдахын зэрэгцээ Шаньси мужийн зарим хэсэг эзлэгдэж, гагцхүү Ганьсү, Ляоян, Юньнань зэрэг төлөөний мужууд алс хол болохоор Мин улсын цэрэг эзлэн авч чадаагүй байлаа.

Их нийслэл Хаанбалгас хот Мин улсад эзлэгдэж, Төмөрбуха, Чинтун сайдууд алагдсан тухай мэдээг Есү жанжин Тогоонтөмөр хаанд бараалхан айлтгажээ. Тэр үед улсын хэргийг оролцон мэдэгч сайд Жан Шоули их нийслэл хотоос зугтан ирэв. Төвлөн засаглах газрын зүүн гарын харилцан туслагч сайд Ширмэн нас нөгчсөн тул Есүбухаг оронд нь томилов. Мөн Нагачу жанжныг Ляоян төлөөний мужийн зүүн гарын харилцан туслагч сайдаар томилжээ.

Тогоонтөмөр хааны хөсөг тэрэг Жундоу-гаар дайрч, удалгүй дээд нийслэл Шанду-д хүрэв. Гэтэл Шанду хотыг аль хэдийн улаан алчууртны бослогын цэрэг довтлон галдан шатааж, тонон дээрэмдсэн учир төвлөрөн суухад хүндхэн болжээ. Энэ үед Ляоян төлөөний мужийн зүүн гарын харилцан туслагч сайд Есү ноён 20000 зоос мөнгө, 5000 ши амуу будаа өргөн барьж тэнхрүүлэн тэтгэв. Шанду хотод ирсний дараа Тогоонтөмөр хаан төр улсын хэрэг явдалд ихэд санаа зовж, өдөр шөнөгүй ажиллаж байжээ. Энэ үед Шанду-гийн төлөөний Цэргийн явдлын хүрээлэнгийн дэд түшмэл Наймантай Тогоонтөмөр хаанд бараалхав. Урьд Шанду хот галд шатан сүйдэхэд Төлөөний Цэргийн явдлын хүрээлэнг Цагаан нуурт байгуулан Шанду-гийн сахин хамгаалагч түшмэл Наймантайг Төлөөний Цэргийн явдлын хүрээлэнгийн дэд түшмэлээр томилжээ. Тэрээр түмэн цэргийг удирдан улаан алчууртны бослогын үлдэгдэл цэргийг цохиж, төвшитгөсөн байна. Түүнийг хүрч ирсэнд Тогоонтөмөр хаан цэргийг нь хишигтэн цэрэг болгов.<sup>6</sup>

Мин улсын цэргийн жанжин Сүсянь-ий удирдсан цэрэг Молтош хаалгаар гарч ирсэнд тус хаалгыг сахин хамгаалж байсан Цэргийн явдлын хүрээлэнгийн бичгийн хэргийг мэдэгч түшмэл Жани зугтан Шанду хотод иржээ. Ийнхүү Мин улсын цэрэг довтлон ирсэнд Их Юань улсын сайд, түшмэд ихэд сандран зарим нь Тогоонтөмөр хааныг Хархорум хот руу явахыг ятгасан боловч хаан эс зөвшөөрөв.

<sup>5</sup> Чуанхэн. Тогоонтөмөр хааны түүх. Үндэсний Хэвлэлийн Хороо, 2005. т.

<sup>6</sup> 刘佑;《北巡私记》, 薄音湖, 王雄;《明代蒙古汉籍史料汇编》第一辑, 内蒙古大学出版社, 2000年, 第3页。

Тогоонтөмөр хаан олон сайд, түшмэдийг зарлигдан дуудаж, төр улсаа дахин сэргээн мандуулах арга бодлогыг хэлэлцэн зөвлөлджээ. Энэ үед хянан байцаагч түшмэл Сү Жинси арван зүйлийн саналыг өргөн мэдүүлэв. Үүнд: 1. Сархадыг цаазлах; 2. Төр улсын хэрэгт ордны захирагчийг оролцуулахгүй; 3. Жанжин сонгох; 4. Тэргүүлсэн сайдад муу хүнийг биш мэргэн, чадвартай хүнийг сонгож томилох; 5. Шан, ялыг тодорхой болгох; 6. Цэргийн цаазыг чангатгах; 7. Цэргийн доторх хөгшин, сул доройг хасах; 8. Баруун хойдын олон газраас цэрэг дайчлах; 9. Корйё улсаас хоол хүнс дайчлах; 10. Чөлөөтэй айлтгах гэсэн саналыг дурджээ.<sup>7</sup> Ингээд Тогоонтөмөр хаан зарим ноёд түшмэлд цол хэргэм соёрхжээ. Хааны зарлигаар Хөхтөмөр жанжныг Чи ванд өргөмжлөн алтан тамга соёрхов. Мөн Есү жанжныг Лян вангаар өргөмжлөн, тайбао цол олгожээ. Динжү-г Төвлөн засаглах газрын улсын хэргийг тэгшитгэн шийтгэгч түшмэлээр томилсон байна.

Тухайн үед Тогоонтөмөр хаан Шанду хотод сууж, Есү жанжны цэргээр сахин хамгаалуулж байв. Харин хунтайж Аюушридарын цэргийн хүрээ Хунлуо шань ууланд байжээ. Хунлуо шань уул нь Шанду хотын зүүн өмнөд талд оршино. Тиймээс Шанду хот нь Хунлуо шань уулын халхавчинд эрэмшиж, харин Хунлуо шань уул нь Шанду хотын тусламжид түшиглэж байлаа.<sup>8</sup>

Шаньси төлөөний мужийн улсын хэргийг тэгшитгэн шийтгэгч сайд Тойнтөмөр ирж Тогоонтөмөр хаанд бараалхав. Хаан Шаньси-гийн хэрэг явдлыг асуухад тэрээр Ли Сичи, Жан Зундао нар урвах санаатайг мэдүүлжээ.

1369 оны цагаан сард Мин улсын жанжин Чан Үйчүн-ий удирдсан цэрэг Датун-ыг довтолсонд тэгшитгэн зөвлөгч түшмэл Жүжэнь умар зүгт зугтааснаар Датун Мин улсад эзлэгдэв. Гурван сард Сүда жанжны удирдсан цэрэг Лүтай-г довтолсонд Жан Лянби зугтан явсаар Фэнюань чөлгөө эзлэгджээ. Чан Үйчэнь, Фэншэн хоёр жанжин хүч хавсран Фэнсян-ыг цохисонд Ли Сичи эсэргүүцэн байлдалгүй Линьтао-д зугтсанаар Фэнсян бас эзлэгдэв. Удалгүй Сүда жанжны удирдсан их цэрэг Гүнчэн чөлгөөг эзэлсэн байна. Энэ үед Фэншэн-гийн удирдсан цэрэг Линьтао-г дайрсанд Ли Сичи газар нутгаа өргөн барьж Мин улсад бууж өгчээ.<sup>9</sup> Үүний дараа Мин улсын цэрэг Лань жоу довтолсонд Үй ван Раднаашир хөсөг тэргээ хаян зугтжээ. Ингэснээр Пинлян, Яньань дараагаар Мин улсад эзлэгдэв. Жан Лянби Няня-д зугтан очоод Хөхтөмөр жанжинд баригджээ. Түүний дүү Жан Лянчэнь Чинян хотыг Мин улсад өргөн бариад бууж өгчээ. Гэвч удалгүй тэрээр Мин улсын жанжин Сүйсянь-ийг алаад бослого гаргасан байна.

Тухайн үед харилцан туслагч сайд Есү Мин улсын цэргийг баруунш хөдөлснийг далимдуулан их нийслэл хотыг байлдан эзлэхээр мордож Тун жоу-д хүртэл Мин улсын жанжин Чан Үйчэнь Лун гуань-аас цэрэг татан авчирч эсэргүүцэн байлдаж Эсү ноёны цэргийг бут цохив. Тэгээд Мин улсын жанжин Чан Үйчэнь явган болон морьт арван түмэн цэргийг дайчлан Ляоси хязгаараас

<sup>7</sup> 刘佑:《北巡私记》, 薄音湖, 王雄:《明代蒙古汉籍史料汇编》第一辑, 内蒙古大学出版社, 2000年, 第4页。

<sup>8</sup> Чуанхэн. *Тогоонтөмөр хааны түүх*. Үндэсний Хэвлэлийн Хороо, 2005. т.

<sup>9</sup> Түжи. *Монголын түүхэн тэмдэглэл*. Дэд дэвтэр. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 2011. т. 936

хөдөлж, Хүй жоу-гаар өгсөн довтлон ирсэнд Эсү ноён Чуаньнин-д тосон байлдаад ялагдав. Эсү ноён цэргээ ухраан Дамао шань ууланд суужээ. Мөн Их Юань улсын жанжин Ван Вэньчин-гийн цэрэг Жинь жоу-д ялагдсан тул Син жоу бас Мин улсын эрхшээлд оржээ.

Тогоонтөмөр хаан Хөхтөмөрт удаа дараа элч томилон зарлигаар дуудсан боловч, түүнээс ямар ч сураг чимээ ирсэнгүй. Тэр үед Хөхтөмөр жанжин Жинин-ээс их цэргээ хөдөлгөж, умард зүгт Яньмэнь боомтоор гарч зам тойрон яваад Цавчаал боомтод орох хэмээн Бао ань-д хүртэл, Мин улсын цэрэг түүний ар хударгаар нь Шаньси-гийн Тайюань дахь Хөхтөмөрийн цэргийг хүрээг довтлохоор мордсон тухай мэдээг олж сонсоод нэн даруй цэргээ буцаан татаж, Тайюань-ийг сахин хамгаалжээ. Удадгүй Мин улсын цэргийн ерөнхий жанжин Сүда, дэд жанжин Чан Үйчүнэ нарын удирдсан их цэрэг шөнө дөлөөр Хөхтөмөрийн цэргийн хүрээг гэнэдүүлэн цохих үед, түүний жигүүрийн жанжин Хуо Бима дайсанд урваж, Мин улсын цэрэгтэй хүчин хавсарсан довтолсонд Хөхтөмөрийн цэрэг ихэд дарагдаж, цөөн хэдэн шадар жанждын хамтаар зугтан гарчээ.<sup>10</sup> Ингээд Шаньси, Хэбэй-гийн газар орон Мин улсад эзлэгдсэн байна.

Эсү ноёны цэрэг ялагдаж, Хөхтөмөр жанжнаас хэл чимээ тасарсан үед Тогоонтөмөр хаан арга буюу олон сайд, түшмэдтэй хэлэлцэн Шанду хотоос ухран Инчан фү-г зорин мордов. Тогоонтөмөр хааны зарлигаар Хэнань ван Буха, Төвлөн засаглах газрын улсын хэргийг тэгшитгэн шийтгэгч сайд Динжү нар Шанду хотыг сахин хамгаалахаар үлджээ.

Мин улсын дэд жанжин Чан Үйчүнэ туршуул илгээн тагнаж мэдээд шилдэг морьт цэргийн арван өдрийн хоол хүнсийг бэлтгэн өдөр шөнөгүй довтолгов. 1368 оны найман сард Хунлуо шань уул болон Шанду хотыг эзлэв. Их Юань улсын хаан говийн зүг Инчан фү хот руу оджээ. Арван сард Их Юань улсын их нийслэл хотын нэрийг Бэйпин фү хэмээн өөрчлөн нэрлэв.<sup>11</sup>

Энэ үед Тогоонтөмөр хааны хөсөг тэрэг Инчан фү хотод хүрчээ. Хааны бие ихэд чилээрхэв. Төрийн сайд, түшмэд Хархорум хот руу очих асуудлыг дахин хэлэлцээ. Энэ үед Гуань Иньнү ноён саналаа хэлсэн нь *“Баруун хязгаарын олон жанждыг зарлигдан Датун-г цохиулбаас, дайсан хойнох чөлгөөд анхаарал хандуулах үед зовлонгоос ангижирч болно”*<sup>12</sup> гэв. Ингээд түүний саналыг ёсоор болгож, Төрэлбэй, Кунсин нарын жанждаар цэрэг удирдуулан Датун-г довтлуулсан байна. Гэтэл тэдний цэрэг Мин улсын Ли Вэньжун-гийн удирдсан цэрэгт бут цохигджээ. Энэ үед Сүда жанжны удирдсан цэрэг Чинян-ыг эзлэн аваад Жан Лянчэнь-ийг алснаар Гуаньлун-гийн газар цөм Мин улсад эзлэгджээ.

Инчан фү хот нь улаан алчууртны бослогын цэрэг дайран өнгөрөөгүй болохоор хот нь уг хэвээр боловч зургаан хамгаалах цэрэг (хишигтэн цэрэг) ирснээс хойш амуу будааны нөөц үл хүрэлцэх болов. Харажан ноён энэ тухай

<sup>10</sup> Идэр Д. Хөхтөмөр жанжин. УБ., 2023.т. 90-91

<sup>11</sup> 《北平录》，薄音湖，王雄；《明代蒙古汉籍史料汇编》第一辑，内蒙古大学出版社，2000年，第8页。

<sup>12</sup> 刘佑；《北巡私记》，薄音湖，王雄；《明代蒙古汉籍史料汇编》第一辑，内蒙古大学出版社，2000年，第6页。

айлтгасан боловч Тогоонтөмөр хаан ямар ч арга хэмжээ авч чадсангүй. Энэ үед Шаньси төлөөний мужийн зүүн гарын туслагч сайд Ван Кэчин Инчан хотод хүрч ирэв. Тэрээр Хөхтөмөрийн вангийн ордонд очиж, түүний айлтгалыг хавсарган хөсөг тэргийг хурдан Хархорумд хүргэхгүй бол Инчан хот найдвартай газар биш хэмээн гуйв. Хааны зарлигаар хунтайж Аюушридаргаар төр улсын бүх хэрэг, цэргийг ерөнхийлөн захируулсан байна.

1370 оны дөрвөн сард Тогоонтөмөр хааны бие чилээрхэж Инчан фү хотод нас нөгчив. Түүхч Рашпунцаг бичсэн нь: *“Ухаант хаан хотол монгол улсаа эзлэн Барс хотноо нэг жил илүү суугаад тавин нэгэн насандаа цагаан нохой жил халив”*<sup>13</sup> гэжээ. Тайвэй түшмэл Өлзий, Цэргийн явдлын хүрээлэнгийн мэдэгч түшмэл Гуань Иньнү нар хааны шарилыг авч умард хязгаар дахь дээдсийн онгоны газарт аваачиж онголов.

Урьд Тогоонтөмөр хаан Молтош хаалгаар ухран зугтахдаа төр улсаа алдсандаа ихэд гашуудан шүлэглэсэн байна. Тэрхүү шүлэгт өгүүлсэн нь:

*...Хаан эзний зөөсөн их нэр төрийг  
Гайхамшиг Сэцэн хааны барьсан хайран Дайдуг  
Хамаг улс шүтээн тулга эрдэнэт хотыг  
Хамж автвай, Хятад улсад, Хайран Дайдуг  
Хан тэнгэрийн хөвгүүн Чингис хааны алтан ураг  
Хамаг бурханы хувилгаан  
Сэцэн хааны алтан харшийг  
Хамаг бодисун нарын хувилгаан Ухаат хаан  
Хан тэнгэрийн заяагаар алдвай, хайран Дайдуг  
Хан эзний хасбуу тамга ханцуйлж гарвай  
Хамаг дайсны дотроос хатгалдаж гаргавай...*<sup>14</sup> гэжээ.

Ийнхүү Чингис хааны төрсөн 1162 оноос 207 жил, эзний хан орноо суусан 1206 оноос 180 жил буюу 1368 он хүртэл Монголын арван таван хаад төрийг барьжээ. Монголчууд уван цуван хатгалдан буруулан гарсан нь дөчин түмэн Монголоос, зургаан түмэн нь гарч гучин дөрвөн түмэн нь хаагдаж хорсон билээ.<sup>15</sup>

1368 онд Тогоонтөмөр хаан Мин улсын цэргийн түрэмгийллийн улмаас их нийслэл Хаанбалгас хотыг орхин гарсан боловч, энэ нь Мин улсын их цэргийн хүчнээс айж эмээсэн хэрэг явдал огт биш билээ. Харин Тогоонтөмөр хаан тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлыг сайтар ухаарсан учраас хамгийн зөв арга замыг сонгосон юм. Тийм ч учраас Тогоонтөмөр хаан 1368-1370 оныг хүртэл хоёр жил шахам хугацаанд Шанду, Инчан фү хотод төвлөрөн сууж байсан нь үнэндээ тэдгээр хотуудаар төв нийслэлээ болгохыг зорьж байсангүй. Харин эдгээр газар орон нь тухайн үед цэрэг-стратегийн чухал түшиц болж байсантай холбоотой юм.

<sup>13</sup> Рашпунцаг. *Болор эрх*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал XIV боть. Дэд дэвтэр. Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн. УБ., 2006. т. 523

<sup>14</sup> Лувсанданзан. *Алтан товч*. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2015. т. 248-249

<sup>15</sup> Саган сэцэн. *Эрдэнийн товч*. Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар хийсэн. М.Баярсайхан. УБ., 2015. т. 155-157



Ийм учраас Тогоонтөмөр хаан эдгээр газар орныг сонгож, Мин улсын цэргийн түрэмгийлэлд шийдвэртэй цохилт өгч их нийслэл Хаанбалгас хотыг эргүүлэн авч, улмаар Их Юань улсын Хятад дахь ноёрхлыг сэргээн байгуулахыг зорьж байсан бөгөөд түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд бүхий л арга бодлогыг сүвэгчилж байжээ. Тогоонтөмөр хааны энэхүү тэмцэл нь хэдийгээр зорилгодоо хүрч чадаагүй боловч Их Юань улсын төрийг мөхөх аюулаас хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй Монголын язгууртнуудын Их Юань улсын Хятад дахь ноёрхлыг дахин сэргээх гэсэн эхний оролдлого байсан юм.

XIV зууны II хагасаас Их Юань улсын олон муж оронд Монголчуудын ноёрхлыг эсэргүүцсэн хятадын ард түмний бослого тэмцэл хүчтэй өрнөж, хорь орчим жилийн ширүүн тэмцлийн үр дүнд Хятад орон дахь Их Юань улсын ноёрхол сүйрч, Монголын улс төрийн төв дахин эх нутагтаа төвлөрсөн билээ. Монголчууд нь 1260 онд умарт хятадыг байлдан эзэлснээс эхлэн тоолбол 108 жил, 1271 онд Их Юань улс байгуулагдсанаас эхэлж авч үзвэл 97 жил, 1279 онд Өмнөд Сүн улсыг байлдан эзэлж бүх хятад орныг эрхшээлдээ оруулснаас эхэлбэл 89 жил монголчууд Хятад орныг эрхшээн ноёрхсон байна. Ийнхүү 1368 онд Их Юань улсын Хятад дахь ноёрхол сүйрснээр түүний эрхшээл нөлөөнд байсан хятад, солонгос зэрэг олон улс орнууд тусгаар тогтнож, салан тусгаарлах бодлогыг баримтлах болсон юм.

**Хоёр. Билэгт хаан Аюушридар Хархорум хотод төвлөрсөн нь.** Билэгт хаан Аюушридар бол Тогоонтөмөр хааны ахмад хөвгүүн билээ. Түүний эх Солонгос угсааны Ги (хятадаар Чи овогт) овогт хатан юм. Тэрээр Корйё улсаас Их Юань улсын хааны ордонд татварлагдан ирж, Тогоонтөмөр хаанд шивэгчнээр үйлчилж байгаад хааны хайр ивээлд багтан их хатнаар өргөмжлөгджээ. Их Юань улсын их хатнаар өргөмжлөгдсөний дараа Ги овогт өөрийн овгийг Солонго, нэрээ Өлзийхутаг хэмээн өөрчилжээ. 1338 онд Тогоонтөмөр хааны Өлзийхутаг хатнаас хөвгүүн Аюушридар мэндэлжээ. 1357 онд Аюушридарыг Их Юань улсын хунтайжаар өргөмжилснөөр Тогоонтөмөр хааныг хавсран төр улсын чухал хэрэг явдлыг шийдвэрлэх болжээ. 1368 онд Тогоонтөмөр хаан Шанду хот руу ухран гарахад хунтайж Аюушридар хамт дагалдан яваад Шанду хотод хүрч, улмаар Инчан фү хотод суужээ.

1370 оны цагаан сард Мин улсын хаан Жү Юаньжан-ы зарлигаар Сүда-г дайсныг дайлах их жанжин, Ли Вэньжун-ыг зүүн гарын цэргийн дэд жанжин, Фэн Гуошэн-г барын гарын цэргийн дэд жанжнаар өргөмжилж, бас Дэнүй, Танхэ нарын хамт элсэн говийн газар орныг дайлаар мордуулсан байна.<sup>16</sup> Сүда-гаар удирдуулсан баруун замын их цэрэг нь Лань жоу дахь Хөхтөмөр жанжны цэргийг цохихоор мордов. Харин Ли Вэньжун-аар удирдуулсан зүүн замын их цэрэг Инчан фү хотод сууж байсан Тогоонтөмөр хааныг цохихоор хөдөлсөн байна.

Тус жилийн дөрвөн сард Их Юань улсын Тогоонтөмөр хаан нас нөгчиж, хунтайж Аюушридар хаан ширээг залгамжилжээ. Энэ тухай “Мин улсын судар”-т тэмдэглэсэн нь “*Хуну-гийн гуравдугаар он [1370 он]...зуны дөрвөн сарын*

<sup>16</sup> 《北平录》，薄音湖，王雄：《明代蒙古汉籍史料汇编》第一辑，内蒙古大学出版社，2000年，第9页。

улаан нохой өдөр Юань улсын хаан Инчан-д нас нөгчиж, хөвгүүн Аюуширидар залгамжлав”<sup>17</sup> хэмээн тодорхой тэмдэглэсэн байдаг. Ийнхүү Тогоонтөмөр хаан тэнгэрт хальж, монголчууд гашуудан эмгэнэж байх үед Мин улсын их цэрэг Инчан хотыг довтолжээ. Түжи-гийн тэмдэглэлд “Хааныг хальсан арван долоо дахь өдөрт Мин улсын цэрэг Инчан фү-г эзлэн авав”<sup>18</sup> гэжээ. Харин Гү Интай бичихдээ “Ли Вэньжун Инчан хотоос зуу гаруй газарт Их Юань улсын морьт цэргийг олзлон асуухад дөрвөн сарын хорин наймны өдөр Тогоонтөмөр хаан нас нөгчсөн хэмээн мэдүүлжээ”<sup>19</sup> гэв. Тэгэхээр Тогоонтөмөр хаан 1370 оны дөрвөн сарын сүүлээр нас нөгчиж, Мин улсын их цэрэг таван сарын дундуур Инчан хотыг эзлэн авчээ.

1370 онд зүүн гарын дэд жанжин Ли Вэньжун арван түмэн цэрэг удирдан Үнэгэн даваан-аас мордож Синхэ-д хүрэхэд түүнийг сахин хамгаалагч жанжин бууж өгөв. Мин улсын цэрэг давшин Цагаан нуурт ирээд Их Юань улсын тэгшитгэн шийтгэгч сайд Жүжэнь-ийг барьж авчээ. Тэгээд Тэмээт ууланд хүрэхэд тэгшитгэн шийтгэгч сайд Шавдан зугтав. Тэндээс Кайпин-д хүрэхэд тэгшитгэн шийтгэгч сайд Шандухан нар бууж өгчээ.<sup>20</sup> Мөн Ли Вэньжун бүгдийг хянагч сайд Сун Синзү Янь шань уулын баруун харуулын дохигч түшмэл Пиндин Дасин газрын зүүн харуулын дохигч түшмэл Панинь нарыг дайчлан Гурван булагт хүрэхэд Их Юань улсын цэрэг довтлон ирснийг Улан коу гэдэг газарт бут цохив. Хайнин харуулын дэд дохигч түшмэл Сунху цэрэг удирдан Луома голын ойролцоо Их Юань улсын тохируулагч түшмэл Майлю-тай байлдан түүнийг алжээ.<sup>21</sup>

1370 оны таван сард Ли Вэньжун-ы удирдсан зүүн замын их цэрэг Инчан хотыг эзлэн авчээ. Энэ үед Юань улсын Билэгт хаан Хархорум руу зугтаж, түүний хөвгүүн Майдарбал нарын 50000 гаруй хүн олзлогдсон байна.<sup>22</sup> Майдарбалын хамт хатад, сул хатад, ордны хүмүүс, олон ван, жанжид, түшмэд зэргийн хэдэн зуун хүмүүс, мөн Сүн болон Юань улсын хасбуу тамга, алтан эрдэнэ 15, хас навчит өргөмжлөл 2, их билигт хас, эрдэнийн бүс, хас сүх тус бүр нэгийг үлэмж их хэмжээний мал сүргийн хамт олзлон авав. Мин улсын их цэрэг Билэгт хааныг Умард Чин жоу хүртэл нэхэн хөөгөөд эс гүйцсэн учир гэдрэг буцжээ. Ли Вэньжун-гийн цэрэг Син жоу газрыг довтлон улсын гүн Жян Вэньчин нарын 37000 хүнийг олзлон авав. Үүний дараа Хунлуо шань ууланд хүрээд Ян Сизү нарын 1600 гаруй хүнийг олзлоод буцжээ.<sup>23</sup> Мин улсын хаан Жү Юаньжан түүний гавьяа зүтгэлийг ихэд сайшааж өндөр цол хэргэмээр шагнасан байна.

Энэ үед Их Юань улсын Билэгт хаан Хархорум хотод ирж төвлөрөн суужээ. Үүнийг гэрчлэх баримт нь 2001 онд Монгол-Германы Хархорум экспедицийн

<sup>17</sup> 《明史 (ming shi)》卷2, 本紀第2, 太祖2, 中華書局, 1974年, 第24頁。

<sup>18</sup> Түжи. *Монголын түүхэн тэмдэглэл*. Дэд дэвтэр. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 2011. т. 938

<sup>19</sup> 谷應泰; 《明史紀事本末》, 中華書局, 1977年, 129頁。

<sup>20</sup> 《明史 (ming shi)》卷126, 列傳第14, 李文忠, 中華書局, 1974年, 第3744頁。

<sup>21</sup> 谷應泰; 《明史紀事本末》, 中華書局, 1977年, 128-129頁。

<sup>22</sup> 《明史 (ming shi)》卷2, 本紀第2, 太祖2, 中華書局, 1974年, 第24頁。

<sup>23</sup> 《明史 (ming shi)》卷126, 列傳第14, 李文忠, 中華書局, 1974年, 第3744頁。



судалгаагаар Билэгт хааны үеийн Сангийн явдлын яамны эрхэлсэн түшмэлийн дөрвөлжин үсэгтэй тамга олдсон явдал юм.<sup>24</sup> Билэгт хааны үед Монголын төрийн улс төрийн төв Монгол орондоо шилжин ирж, Хархорум хотыг дахин нийслэл хот болгосон юм. Хархорум хот нь Их Монгол улсын үеийн нийслэл хот төдийгүй тухайн үеийн олон улсын харилцаа, эдийн засгийн хөгжлийн гол төв байв. Харин Их Юань улсын үед Хархорум хот нь урьдын адил Монгол орны улс төр, эдийн засгийн хөгжлийн гол төв байсан төдийгүй Их Юань хэмээх Их Монгол улсын Хятад дахь засаглал, ноёрхлыг хамгаалах гол сүр хүчин, цэрэг-дайны стратегийн гол түшиц газар байжээ. Өөрөөр хэлбэл, Монголын төр улс Хятадыг 100 орчим жил засаглан ноёрхоход Хархорум хотын гүйцэтгэсэн үүрэг, нөлөө асар их байлаа. Ийнхүү Билэгт хааны засаглалыг дагаж Хархорум хот дахин сэргэж, өнгө жавхаа нь нэмэгдэх болжээ.

Билэгт хаан Хархорум хотод ирээд төр улсаа төвхнүүлэн тогтоож, Хятад дахь засаглал, ноёрхлоо дахин сэргээхийг зорьж байжээ. Тэрээр энэхүү хүсэл, зорилгоо илэрхийлэн оны цолоо Суаньгуан (宣光-xuan guan) хэмээн өргөмжлөн тунхаглав. Хархорум хотоос олдсон Билэгт хааны үеийн Сангийн явдлын яамны эрхэлсэн түшмэлийн тамганы дээд талд “Суаньгуан-ы хоёрдугаар он [1371 он]-ы гуравдугаар сар, өдөр (宣光二年三月日)” гэсэн хятад бичээсийг сийлсэн байдаг. Энэхүү дурсгал нь Билэгт хааны оны цолоо Суаньгуан-ы хэмээн өргөмжилснийг гэрчлэн харуулж байна. Уг оны цол нь Эртний Хятадын Жоу улс болон Хань улсыг сэргээн мандуулж байсан “Суань ван (宣王)”, “Гуану ди (光武帝)” нарын нэртэй холбоотой ажээ. Энэ тухай Солонгосын түүхч Үнь иньсүг бичихдээ: “Монгол нутагт эргэн ирж, хуучин нийслэл Хархорум хотод хаан сууринд суусан Аюушридар хаан Их Юань улсыг сэргээхийг зорьж “Жоу улс хийгээд Хань улсыг дахин сэргээсэн нь Суань ван (宣王) болон Гуану ди (光武帝)-гийн гэгээн сэргэлэнгийн ач болой” хэмээх нэрийн доор “Суаньгуан (宣光)” гэдэг оны цолыг авч хэрэглэжээ”<sup>25</sup> гэжээ. Үнэхээр энэ оны цол нь Их Юань улсын Хятад дахь засаглал, ноёрхлыг дахин сэргээн мандуулахыг бэлгэдсэн утга, агуулгыг илэрхийлж байна.

Их Юань улсын Билэгт хаан Хятад дахь засаглал, ноёрхлоо дахин сэргээн байгуулах бодлого, үйл ажиллагааг идэвхтэй явуулж байх үед Хөхтөмөр жанжин Хархорум хотод хүрч иржээ. Урьд Тогоонтөмөр хааны зарлигаар Хөхтөмөр жанжныг Төвлөн засаглах газрын баруун гарын харилцан туслагч сайд, Чи вангаар өргөмжлөн алтан тамга соёрхсон учир тэрээр Их Юань улсын төрийн голлох зүтгэлтний нэг байв. Ийнхүү Их Юань улсын Билэгт хаан, Төвлөх засаглах газрын сайд Хөхтөмөр нар Хархорум хотод ирж, сүр хүчээ хамтатгасан нь Монголын төр улс мөхөлгүй оршин тогтнох гол нөхцөл, үндэс суурь болсон юм. Ийм ч учраас Билэгт хаан, сайд Хөхтөмөр нар урьдын өш хонзон, зөрчил тэмцлийг умартаж, тухайн үеийн улс төрийн цоо шинэ нөхцөл байдлыг

<sup>24</sup> Эрдэнэбат У. Монголын эртний нийслэл Хархорум. УБ., 2020.т. 283

<sup>25</sup> Үнь иньсүг. Аюушридарын үйл ажиллагаа хийгээд Корйё-Монголын харилцааны хувиралт. // Монгол-Солонгосын харилцааны өнгөрсөн ба одоо. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. УБ., 2000. т. 261

ухамсарлан ойлгож, Монголын төр улсын тусгаар тогтнол, гал голомтыг сахин хамгаалах хийгээд Их Юань улсын Хятад дахь засаг захиргаа, ноёрхлыг дахин сэргээн байгуулахын төлөө тэмцэх болжээ.

Билэгт хаан, Хөхтөмөр сайд нар Мин улсын цэргийн довтолгооноос төр улсынхаа тусгаар тогтнолыг хамгаалахын тулд нэн даруй цэрэг-дайны бодлого, төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч байв. Тэд юуны өмнө цэргийн хүчээ зузаатган Мин улсын их цэргийг утган байлдах дайны бэлтгэлийг хангажээ. Дараа нь Ляодун-ы Нагачу жанжин, Юньнань-ий Лян ван Базарварми зэрэг бутран сарниж, таслагдан хаагдсан Их Юань улсын сайд, түшмэд, цэргийн жанжидтай харилцаа холбоо тогтоож, хамтын цэргийн хүчээр Мин улсын цэргийг бут цохих бодлого, үйл ажиллагааг идэвхтэй явуулж байлаа. Ийнхүү Билэгт хаан, Хөхтөмөр сайд нарын сүр хүчин, хамтын хүчин зүтгэл нь тухайн цаг үеийн монголчуудад дахин сэргэн мандах итгэл найдварыг төрүүлсэн юм.

Тухайн үед Их Юань улсын цэргийн гол хүч Хархорум хотод төвлөрч байжээ. Их Юань улсын цэргийн гол хүчийг Хөхтөмөр жанжин ерөнхийлөн захирсан байна. Хөхтөмөр бол бага залуугаасаа Цагаантөмөр жанжныг олон жил дагалдан явж, түүний цэрэг-дайны бодлого, арга ухаанаас суралцжээ. Тэрээр олон жил Хятадын улаан алчууртны бослогын цэрэгтэй байлдаж явсан болохоор тэдний байлдааны арга, тактикийг сайтар мэдэх ажээ.<sup>26</sup> Тухайн үед Хөхтөмөр жанжныг “Тэнгэрийн доорх баатар эрийн гайхамшиг”, “Төр улсыг сахин хамгаалагч ван (王保保-wang bao bao)” гэх зэргээр нэр алдаршсан тул Мин улсын цэргүүд түүнтэй тулалдахаас сүрдэн эмээдэг байжээ.

Японы эрдэмтэн Вадай сэй Хөхтөмөр жанжны тухай бичихдээ: “...Хөхтөмөр бол Их Юань улсын сүүл үеийн улс төрийн хямрал тэмцлийн үед тодорч гарч ирсэн бөгөөд бууран доройтсон Их Юань улсад шударгаар зүтгэж байсан цорын ганц түшмэл билээ. Урьд Шаньдун, Хэнань-ий бослогыг дарангуйлан төвшитгөж, хоёр удаа Шаньси мужийн Ханьдянь-д Мин улсын цэргийг бут цохижээ....Дараа нь Их Юань улсын төрийг дагаж хойшоо зугтан, говийн ард очиж суусан боловч хэзээнээс сэтгэл зүрхэндээ төр улсаа дахин сэргээн байгуулахыг зорьж байжээ. Тиймээс Хөхтөмөр Мин улсын хил хязгаарыг олон удаа уулгалан довтолж сүрдүүлж байв. Нэн ялангуяа, Хуну-гийн тавдугаар онд (1372 он) Давааны ард Мин улсын их жанжин Сүда нарын их цэргийг бут цохиж, Мин улсад ихээхэн сүрдүүлэг болж, нэг хэсэг хугацаанд говийн ард довтлохоос нь сэргийлжээ.... Мэдээжийн хэрэг ялагдсан, үлдэгдэл цэргээ удирдаж байгаа Хөхтөмөр, шинээр байгуулагдсан Мин улсын цэрэгтэй байлдаж хэдэн удаа ялагдахын гашуун зовлонг амсаж байсан боловч, Мин улс түүний сүр хүчнээс айж дураараа довтолж зүрхэлдэггүй байв. Умард Юань-ий төр зөвхөн түүний хүчийг түшиглэж, төр улсаа дахин сэргээн мандуулах хүсэл эрмэлзэлтэй байсан юм. Үнэнхүү ганцаараа мөхөхөд хүрсэн төр улсын гол түшиг тулгуур нь болж байв”<sup>27</sup> хэмээжээ.

<sup>26</sup> Идэр Д. *Их Юань улс* (1368-1388). УБ., 2013.т.95

<sup>27</sup> 和田清; 《明代蒙古史论集》下册, 商务印书馆出版, 1984年, 第666—667页。

Билэгт хаан, Хөхтөмөр жанжин нар Хархорум хотын орчимд цэргийн хүчээ зузаатгаж, дайны бэлтгэл хангаж буй мэдээ Мин улсад хүрчээ. 1372 онд Мин улсын хаан Жү Юаньжан умардын аюул нүүрлэхээс ихэд санаа зовниж, олон сайд түшмэдийг зарлигдан дуудан зөвлөлдөн хэлэлцсэн байна. Энэ тухай “Мингийн магад тэмдэглэл”-д тэмдэглэсэн нь: *“Төвлөн засаглах газрын баруун гарын харилцан туслагч сайд, Вэйгуо гүн Сүйда хэлсэн нь: “Эдүгээ тэнгэрийн доорх ихэд тогтож, ард түмэн хэдийн амаржиж, Бэйлү (北虜-bei lu) залгаагаар бууж өгсөн боловч ганц Ван Баобая хил хязгаарыг түйвээж, эдүгээ дахин Хархорумд зугтан очиж хэрэг самуун үүсгэж буй тул сайд би цэрэг дайчлан мордож даран устгая” гэв. Хаан айлдсан нь “Буруулсан дайсны зарим нь элсэн говь газарт очсон гэж сонссон, даруй устгаваас зохилтой. Гэвч эдүгээ олонх нь ялагдаж мөхөөд алс хол элсэн газарт өөрийн харуулдаа алагджээ. Буруулсан дайсан хашигдсан араатан эсэргүүцэн тэмцэхтэй адил биз ээ? Тохируулан хүрвэл зохино” хэмээв...Энэ үед Сүда хэлсэн нь: “Арван түмэн цэрэг дайчлан мордоход болно” гэжээ. Ингээд Мин улс их цэрэг дайчлан мордуулж Монгол орныг дайлан төвшитгөхөөр шийдвэрлэсэн байна.*

1372 оны цагаан сард Мин улсын хаан Жү Юаньжан-ы зарлигаар Вэйгуо гүн Сүда-г Бэйлү-г дайлах их цэргийн жанжнаар томилоод Янь мэнь-ээр гарч, Хархорумд үтэр хүр, Цаогуо гүн Ли Вэньжун-ыг зүүн гарын дэд жанжнаар томилоод Инчан-аас гар, Сунгуо гүн Фэншэн-г баруун гарын дэд жанжнаар томилон Ганьсү-г эзэлж, Хөхтөмөрийг дайлахаар мордуулжээ.<sup>28</sup> Ийнхүү Мин улсын гурван замын их цэрэг Их Юань улсыг довтлон цохихоор Монгол оронд цөмрөн оржээ.

Мин улс Их Юань улсыг мөхөөж, Монгол орныг эзлэн авахын тулд үлэмж их хэмжээний цэргийн хүчийг дайчлан мордуулсан байна. Мин улсын цэргийн тоог хятад сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэжээ. Тухайлбал, “Мин улсын судар”-т тэмдэглэсэн нь *“Олон жанжид 5 түмэн цэрэг дайчлан боомтоос гарав”*<sup>29</sup> гэжээ. Харин “Мингийн магад тэмдэглэл”-д бичсэн нь *“15 түмэн цэргийг гурван зам хувааж давшив”*<sup>30</sup> гэсэн байдаг. Үүнээс үзвэл Мин улсын гурван замын цэрэг нь тус бүр 50000 цэрэгтэй, нийтдээ 150000 цэргээр Их Юань улсыг довтолсон байна.

Сүда жанжнаар удирдуулсан Мин улсын дунд замын их цэрэг тус жилийн гурван сард Шаньси газрын хилд хүрч иржээ. Тэгээд бүгд хянагч түшмэл Ланьүй-г хошууч жанжнаар томилоод Хөхтөмөр жанжны цэрэгтэй Тахийн голд тулалдан ухраав. Үүний дараа Мин улсын цэрэг Туул голын орчимд Хөхтөмөр жанжны цэрэгтэй байлдахад бас л зугтан оджээ. Гэтэл Хөхтөмөр жанжин Хэ Зунжэ жанжны цэрэгтэй хүч хавсран Мин улсын цэргийг довтолсон байна. Хоёр талын цэрэг хэдэнтээ тулалдсаны эцэст Мин улсын цэрэг бут цохигдож, 10000 гаруй цэргээ алджээ.<sup>31</sup> Ийнхүү Хөхтөмөр жанжин Мин улсын дунд

<sup>28</sup> 《明實錄 (ming shi lu)》，《明太祖實錄》卷71，洪武五年春正月庚午条。和田清；《明代蒙古史論集》上册，商务印书馆出版，1984年，第16页。

<sup>29</sup> 《明史 (ming shi)》卷2，本紀第2，太祖2，中華書局，1974年，第26-27頁。

<sup>30</sup> 《明史 (ming shi)》卷125，列傳第13，徐達，中華書局，1974年，第3729頁。

<sup>31</sup> 谷應泰；《明史紀事本末》卷10，古元遺賓，中華書局，1977年，133頁。

замын цэргийг цөөн цэргээр өдөөн хатгаж байлдаад зугтан хойноосоо хөөлгөн дагуулсаар цэргийнхээ гол хүч дээр авчран бут цохидог монгол цэргийн байлдааны аргыг ашиглан устгасан байна.

Фэншэн жанжны удирдсан баруун замын их цэрэг нь Лань жоу-д хүрээд Фү Юүдэ жанжнаар 5000 морьт цэргийг захируулан хошууч болгон Силян хотыг довтлуулав. Түүний цэрэг Их Юань улсын жанжин Шициханы цэрэгтэй тулгаран байлдаж ялаад Юнчан хүртэл нэхэмжлэн хөөжээ. Үүний даар Их Юань улсын тайвэй Доржвагийн цэргийг Хулхан ам гэдэг газарт бут цохиод хөсөг тэрэг, мал сүргийг үлэмж ихээр олзлон авчээ. Ингээд Фү Юүдэ-гийн цэрэг Саолинь шань ууланд хүрэх үед Фэншэн жанжны удирдсан их цэрэг иржээ. Мин улсын баруун замын их цэрэг довтлон Их Юань улсыг цэргийг цохих үед Фү Юүдэ туслагч сайд Бухааг харван алаад 400 гаруй цэргийг хөөн цавчиж, тайвэй Соноржа, тэгшитгэн шийтгэгч сайд Гуаньжэ нарыг буулган авчээ.<sup>32</sup>

Мин улсын баруун замын их цэргийн сүр хүчнээс эмээсэн Их Юань улсын түшмэд, жанжид ээлж дараагаар бууж өгөв. 1372 оны зургаан сард Их Юань улсын жанжин Шандулу харьяат аймгийн түшмэл, иргэн 830 гаруй өрхөө дагуулан Мин улсад дагаар оржээ. Мөн Фэншэн жанжны цэрэг Эзнээ чөлгөөд хүрч ирэхэд сахигч жанжин Буянтөмөр бууж өгөв. Улмаар түүний цэрэг Бизя ууланд ирээд Их Юань улсын Чи ван Доржбал, Жан Жяну нарын 27 түшмэл, мөн мал сүрэг 10 гаруй түмийг олзолжээ. Энэ үед Фү Юүдэ-гийн удирдсан цэрэг Гуаша жоу-г довтлон Их Юань улсын цэргийг бут цохиод алт, мөнгөн тамга болон мал сүрэг 2 түм гаруйг олзлон буцжээ.<sup>33</sup> Ийнхүү Мин улсын баруун замын цэрэг нь амжилттай довтлон ялалт байгуулан буцсан байна.

Ли Вэньжун удирдсан Мин улсын зүүн замын цэрэг Хэрлэн гол орчмоор Монгол оронд цөмрөн орж иржээ. Тэрээр бүгд хянагч түшмэл Хэ Вэньхүй жанжны цэргийг хошууч болгон Гүн хэмээх газарт довтлон ирэхэд Их Юань улсын цэрэг буруулан зугтсан тул тэдний үлэмж их хөсөг тэрэг, мал сүргийг олзлон авав. Тэгээд цаашлан давшаад Хэрлэн голын орчимд хүрэх үед Ли Вэньжун шуурхай довтлохын тулд зарлигдан тушааж, ачаа хөсгөө үлдээн Ханьжэн нарын жанждаар сахиулан хамгаалуулаад цэрэг бүрд хорин өдрийн хүнс өгөөд яаравчлан морджээ. Мин улсын их цэрэг Туул голын орчимд довтлон ирэхэд Их Юань улсын тайш Харажан, Манзи нар угтан байлдав. Хоёр талын цэрэг ширүүн тулалдсаны эцэст Их Юань улсын цэрэг Орхон гол руу ухарчээ. Мин улсын цэрэг нэхэмжлэн хөөж ирсэнд Их Юань улсын цэрэг Орхон голын дэргэд дахин хориглон тулалджээ. Энэ үед Ли Вэньжун-ы унаж явсан морь нь тэнэсэн суманд оногдож, явгарсан байна. Гэтэл шадар хамгаалагч Лирун санд мэнд өөрийн унаж явсан морио Ли Вэньжун-д өгч тулалдуулсанд Их Юань улсын цэрэг буруулан оджээ. Ли Вэньжун тэднийг нэхэмжлэн цохиж Чэнхай гэдэг газарт хүрэх үед Их Юань улсын цэрэг довтлон ирж ширүүн тулалдаж, Мин улсын цэргийг бут цохив. Ли Вэньжун-ы цэрэг ялагдаад буцах замдаа

<sup>32</sup> 谷應泰；《明史紀事本末》卷10，古元遺賓，中華書局，1977年，134頁。

<sup>33</sup> 谷應泰；《明史紀事本末》卷10，古元遺賓，中華書局，1977年，134頁。

төөрч, уух усгүй болсны улмаас маш олон цэрэг нь харангадаж үхжээ. Удалгүй Ли Вэньжун-ы цэрэг ундны устай залгаад цэргээ зам хуваан довтлон элсэн говьд орсон боловч хоол хүнс нь дууссаны улмаас Их Юань улсын цэрэгтэй тулалдаад бут цохигдов.<sup>34</sup> Ингээд Ли Вэнь жун цөөн цэргийн хамтаар нийслэлдээ буцжээ.

Мин улсын хаан Жү Юаньжан их цэргийн хүчээр Монгол орныг довтлон Их Юань улсыг мөхөөж, эрхшээлдээ оруулахыг зорьсон боловч амжилтад хүрээгүй юм. Энэ тухай “Мин улсын судар”-т *“Сүда Юань улсын цэрэгтэй элсэн говийн ард тулалдан ялагдав”*<sup>35</sup> хэмээн маш товчхон тэмдэглэсэн байдаг. Харин зарим хятад сурвалж бичгүүдэд Мин улсын хаан Жү Юаньжан энэ дайны шалтгааныг түүнийг биелүүлж чадаагүй гурван том хэрэг явдалтай холбож үзжээ. Тухайлбал, *“Гаоди хаан (Жү Юаньжан) дэлхий дахиныг нэгтгэн захирсан атал басхүү гурван хэргийг биелүүлж чадаагүй билээ. Нэгдүгээрт, хааны хасбуу тамга дутах, хоёрдугаарт, Ван Баобао (Хөхтөмөр)-г барьж чадаагүй, гуравдугаарт, Их Юань улсын хунтайжийн сураг чимээг гаргаж чадаагүй. Иймээс гурван замаар цэрэг дайчлан говийн ард байлдаад ихэд ялагдаж, үхэж шархадсан нь дөч гаруй түмд хүрчээ”*<sup>36</sup> гэв. Ийнхүү Мин улсын хаан Жү Юаньжан Их Юань улсыг цэрэг, зэвсгийн хүчээр эрхшээлдээ оруулахыг зорьсон боловч амжилтад хүрсэнгүй. Тэрээр Их Юань улсыг урьдын адил хүчирхэг хэвээр оршин тогтнож байгааг сайтар ойлгосон юм.

1372 оны Юань-Мингийн дайны тухай монгол сурвалж бичгүүдэд сонирхолтой мэдээ баримтуудыг тэмдэглэсэн байдаг. Лувсанданзангийн “Алтан товч”-д бичсэн нь: *“...Молтогчин сүвээр гарч, Барс хот барьж суув. Хятадын цэргүүд Хирса хот барьж суув. Тэнд Ухаант хааны хөвгүүн Билэгт зад барьж, их шуурга, бороо оруулан Хятадын цэргийн эр, агтыг бадартал үхүүлэв. Түүнээс үлдсэн цэргүүд харьж ирэхүйд, Монголын цэрэг нэхэж хэрэм хүртэл цавчив гэх. Түүнээс тархаж дутаасан цэрэг нь зуун зэвээ түлж, зуухандаа хэвтэж үхэв гэх. Хятад хярд гарав, хярсны сүүл залаа болов гэх тэр буюу”*<sup>37</sup> гэжээ. Үүнээс үзвэл, Билэгт хаан зад барих онцгой чадвартай байсан нь Мин улсын цэргийг бут цохиход нөлөө үзүүлсэн байна.

Түүхчид энэхүү дайны тухай олон янзын санал, дүгнэлтийг дэвшүүлсэн байдаг. Монголын эрдэмтэн Ч.Далай үзэхдээ “...Мин улсын Чжу юанчжан хааны тушаалаар 1372 онд Сюй Да, Ли вэнь жун нарын 2 жанжнаар удирдуулсан Хятадын 15 түмэн цэрэг гурван замаар Ар Юан монгол улсын нутгаар түрэмгийлэн орж ирээд хангайн уулын ард их сүржнээр хороолон буудаллажээ. Хятадын харгис цэрэг монголчуудыг цохиж эрхэндээ оруулж улмаар Хархорум хотыг эвдлэн сөнөөх зорилготой иржээ. Гэвч Хөхтөмөр цэргээ авч тосон байлдаж дайсны цэргийг хиар цохижээ. Мин улс байгуулагдсаар Хятадын цэрэг анх

<sup>34</sup> 谷應泰：《明史紀事本末》卷10，古元遺賓，中華書局，1977年，134-135頁。

<sup>35</sup> 《明史(ming shi)》卷2，本紀第2，太祖2，中華書局，1974年，第27頁。

<sup>36</sup> 錢謙益：《國初群雄事略》卷11，《河南擴廓帖木兒》，中華書局，1954年，第264頁。

<sup>37</sup> Лувсанданзан. *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой*. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006. т. 232



удаа хамгийн том ялагдал хүлээжээ. Нөгөө хувилгаан бурхан мэт ялагдашгүй хүчит Сюй Да жанжин монгол нутагт ичгүүртэйгээр ялагдал хүлээж, үлдэгдэл цэргээ авч амь зулбан зугтаажээ. Монголчууд ингэж л эх орноо хамгаалж байсан түүхтэй. “Ялагдашгүй баатар Хөхтөмөр” гэдэг нэр томьёо чухам тэр үеэс л түүхэнд тэмдэглэгджээ”<sup>38</sup> хэмээн бичжээ.

1372 оны дайнд Мин улс ялагдсаны дараа Их Юань улстай байлдахдаа ихэд болгоомжтой хандах болжээ. Энэ тухай “Мин улсын судар”-т тэмдэглэсэн нь: “*Мин улсын Лиүжи хэмээх түшмэл Мин улсын хаанд айлтгасан нь: “Хөхтөмөрийг цохиход үнэхээр хялбар биш юм” хэмээв. Мин улсын хаан: “Би цэрэг мордуулаад ингэж ихээр ялагдаж үзээгүй, олон ноёд түшмэд Хархорумд ихээр ялагдсан учраас одоо ихэд болгоомжтой хандах хэрэгтэй”*”<sup>39</sup> гэжээ. Ингээд Мин улсын хаан Жү Юаньжан Сүда, Ли Вэньжун нарт зарлиг буулгаж, Цагаан хэрмийг дахин сэргээн засварлаж, түүний дагуух цэргийн бэхлэлт, боомт газруудын хамгаалалтын хүчийг нэмэгдүүлээд Их Юань улсын цэргийн довтолгооноос сэргийлэн хамгаалуулжээ. Ингэснээр Юань-Мингийн хил хязгаар нь Цагаан хэрмээр тогтсон байна.

Билэгт хаан, Хөхтөмөр сайд нарын хамтын хүчин чармайлтын үр дүнд Мин улсын цэргийн түрэмгийллийг тас цохиж, Монголын төр улс уугуул эх нутагтаа төвхнөн тогтож, хүчирхэгжин мандсан билээ. Тухайн цаг үеийн Монголын төр улсын гол түшиг тулгуур, сүр хүчин болж байсан сайд Хөхтөмөр 1376 онд нас нөгчиж, удалгүй 1378 онд Билэгт хаан тэнгэрт хальснаар Их Юань улсын Хятад дахь засаглал, ноёрхлоо дахин сэргээн байгуулах бодлого амжилтад хүрч чадаагүй юм.

**Гурав. Усхал хаан Төгстөмөр Буйр нуурын газарт хүрээлсэн нь.** 1378 онд И ван Төгстөмөр Их Юань улсын хаан суурийг залгамжлаад хаан цолоо Усхал, оны цолоо Тяньюань хэмээн өргөмжилжээ. Тэрээр хаан өргөмжлөгдсөний дараа Билэгт хааны бодлогыг үргэлжлүүлж, Мин улсыг эсэргүүцэн тэмцэж, Их Юань улсын тусгаар тогтнолыг хамгаалах, Хятад дахь засаглал, ноёрхлыг сэргээн байгуулахыг зорьсон билээ. Энэ үед Усхал хааны гол түшиг тулгуур нь харилцан туслагч сайд Люар, Манзи, Харажан, улсын гүн Тохуч, тэгшитгэн шийтгэгч сайд Өлзийбуха, Найрбуха, Цэргийн явдлын хүрээлэнгийн мэдэгч Айзү зэрэг олон сайд, түшмэд байжээ.

Усхал хааныг Их Юань улсын хаан өргөмжилсөн нь Мин улсын бодлогод эс нийцсэн учир хоёр улсын харилцаа дахин хурцдаж, дайн байлдаан өрнөсөн байна. Мин улсын хаан Жү Юаньжан урьд олзлогдон чунли хоу цол өргөмжлөн буцаасан Майдарбалыг Их Юань улсын хаан ширээг залгамжлуулахыг хүсэж, нөлөө бүхий сайд, түшмэдийг ятгаж, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс хутгалдан оролцохыг санаархаж байсан боловч амжилтад хүрээгүй юм. Ийм учраас Мин улс их цэрэг дайчлан мордуулж, Усхал хааныг цэрэг зэвсгийн хүчээр буулган авах бодлогыг баримтлах болов.

<sup>38</sup> Далай Ч. *Монголын түүх* (1260-1388). Гутгаар дэвтэр. УБ., 1992. т. 142

<sup>39</sup> 《明史 (ming shi)》卷124, 列傳第12, 擴廓帖木兒, 中華書局, 1974年, 第3712頁。



Тухайн үед Усхал хаан Хархорум хотод төвлөрөн сууж, Мин улсын эсрэг идэвхтэй бодлого, үйл ажиллагааг явуулж байжээ. 1380 оны хавар Мин улсын хаан Жү Юаньжан зарлиг буулган Усхал хааныг дайлуулахаар их цэргийг дайчлан мордуулжээ. Энэ тухай *“Мин улсын судар”-т тэмдэглэсэн нь “Арван гуравдугаар оны хавар Сипин хоу Мүин өрлөг жанжсин Линь жоу-гаар гарч Хуан хэ голыг гаталж, Хэлань шань уулыг даван, элсэн говийг туулаад Хархорумыг довтоллон Тохуч, Айзү нарыг олзлон авч, түүний харьяатуудыг хядаж дуусгаад буцав”* <sup>40</sup> гэжээ. Харин Гү Интай-гийн “Мингийн түүхийн эх адгийн хэргийн тэмдэглэл”-д бичсэн нь *“Арван гуравдугаар оны хаврын гуравдугаар сард Юань улсын гуо гүн Худуч (Тохуч-Д.И), хүрээлэнгийн мэдэгч Айзү нар Хархорумд суугаад хил хязгаарыг уулгалах болсон тул зарлигаар Сипин хоу Мүин жанжин Шаньси-гийн цэргийг ерөнхийлөн захирч мордоод тэднийг дайлав. Эзнээ чөлгөөгөөр Хатан голыг гаталж, Хэлань уулыг даван, элсэн говийг туулаад Хархорумын хязгаарт хүрчээ. Тэгээд тавин газарт ойртон ирээд Мүин жанжсин цэргээ дөрвөн зам хуваажээ. Нэг замын цэргийг дайсны араас довтолуулаад, хоёр замын цэргээр зуун, баруун талаас хавчин цохиулж, Мүин жанжсин гол замын цэргээр өмнө талаас нь хошуучлан довтолсон байна. Түүний цэрэг шөнө дөлөөр чимээ гаргалгүй давшиж, дайсныг бүслэн авчээ. Худуч нар үймэн сандарч, арга мухардсан тул бүгдээр буун өгсөнд түүний харьяат олныг цөмийг нь олзлон буцав”* <sup>41</sup> гэжээ. Мин улс 1372 онд Сүда жанжны удирдсан их цэрэг Их Юань улсад бут цохигдон ялагдсанаас хойш дахин их цэргийг дайчлан мордуулаагүй юм. Харин 1380 онд Мүин жанжны удирдсан дөрвөн замын их цэрэг Хархорумыг довтоллон эзэлж, их ялалт байгуулан буцжээ.

Хархорум хотод төвлөрөн сууж байсан Усхал хаан Мин улсын Мүин жанжны их цэрэг довтоллон ирэх үед Тохуч, Айзү нараар сахин хамгаалуулаад зугтан одсон бололтой. Энэ дайны тухай түүхийн сурвалж бичгүүдэд нарийн тодорхой мэдээ баримт байхгүй. Тийм учраас 1380 онд Мин улсын Мүин жанжны цэрэг Хархорум хотыг эзлэн авч, эвдэн сүйтгэн, шатааж устгасан гэж үзэхэд баримт нотолгоо хомсон юм. Гэвч Усхал хаан Хархорумаас дайжин Буйр нуурын газарт очиж суусан, мөн Хархорумд сууж байсан Их Юань улсын Тохуч, Айзү нарын сайд, түшмэд харьяат албатуудын хамт олзлогдсон хэрэг явдлаас таамаглан үзэхэд Хархорум хот 1380 онд мөхсөн бололтой. Өөрөөр хэлбэл, 1380 онд Мин улсын Мүин жанжны удирдсан дөрвөн замын их цэрэг Хархорум хотыг эзлэн авч, эвдэн сүйтгэж, шатаан устгажээ.

Сүүлийн үеийн Хархорум хотод гүйцэтгэж буй археологийн шинжилгээний үр дүнд малтан шинжилсэн бүх үе давхаргаас дээж авч орчин үеийн байгалийн судалгааны аргаар хотын түүхэн болон археологийн үечлэлийг тодруулан тогтоох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Судалгаанаас үзэхэд Их Монгол улсын анхны нийслэл Хархорум хот нь XIII зууны тэргүүн хагаст үүсэн хөгжиж XIV зууны төгсгөл буюу Хятадын Мин улсын цэрэг 1380, 1388 онд эвдэн сүйтгэхийг хүртэл хотын амьдрал нэн идэвхтэй өрнөж байсан нь нотлогджээ.<sup>42</sup>

<sup>40</sup> 《明史 (ming shi)》卷327, 列傳第215, 外國8, 韃靼, 中華書局, 1974年, 第8465頁。

<sup>41</sup> 谷應泰; 《明史紀事本末》卷10, 古元遺賓, 中華書局, 1977年, 141頁。

<sup>42</sup> Эрдэнэбат У. Монголын эртний нийслэл Хархорум. УБ., 2020. т. 340

Усхал хаан Хархорум хотоос дайжин зугтаад Буйр нуурын газарт ирж суусан байна. Тухайн үед Усхал хаан яагаад Буйр нуурын газарт зугтсан, чухам ямар нэртэй хотод суусан тухай түүхийн сурвалж бичгүүдэд тодорхой тэмдэглэл байхгүй ажээ. Харин Саган сэцэний “Эрдэнийн товч”, Галдангийн “Эрдэнийн эрих” хэмээх сурвалж бичгүүдэд *“Тогоонтөмөр хаан зургаан түмнээ цуглуулан Хэрлэн мөрний хязгаарт хүрч, Барс хот хэмээхийг барьж суусан”*<sup>43</sup> тухай тэмдэглэсэн байдаг. Гэтэл Тогоонтөмөр хаан их нийслэл Хаанбалгас хотоос ухран Шанду хотоор дамжин Инчан фү хотод сууж байгаад тэнгэрт халин одсон билээ. Тийм учраас Тогоонтөмөр хаан Хэрлэн мөрөнд хүрч Барс хот байгуулаагүй юм. Эдгээр сурвалж бичгүүдэд түүхэн хэрэг явдлын эзэн биеийг эндүүрч ташааран тэмдэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, Тогоонтөмөр хаан биш, түүний удаах хөвгүүн Усхал хаан Төгстөмөр Хэрлэн мөрний хязгаар нутагт хүрч Барс хотыг барьж байгуулсан байх магадлалтай юм. Хятад сурвалж бичгүүдэд Усхал хааныг Хархорумаас зугтан Буйр нуурын газарт цэргийн хүрээгээ байрлуулсан тухай тэмдэглэдэг. Тиймээс Усхал хаан Буйр нуурын газарт төвлөрөн сууж Мин улсын эсрэг ширүүн тэмцэл өрнүүлж байв. Тэрээр Мин улсын цэргийн довтолгоог эсэргүүцэн хамгаалах зорилгоор цэргийн бэхлэлт хот байгуулсан байж болох юм. Хэрэв тийм бол Барс хотыг байгуулсан нь лавтай. Гэвч түүхийн сурвалж бичгүүдэд үүнийг нотлох мэдээ баримт олдохгүй байна.

Хэрлэн Барс хотыг эрдэмтэн Х.Пэрлээ малтан судалжээ. Түүний шинжилснээр “1953 онд явуулсан эртний судлалын хайгуулаар Хэрлэн Барс хотын хуучин үлдэгдэлтэй холбогдох хоёр хэрмийг Барс хотын ойролцоо илрүүлэн олжээ. Гурван хэрмийг хооронд нь сольж самуурахгүйн тулд тусгай дугаар зохиосон юм. А. Нутгийн ардууд Барс хот гэдэг өндөр суваргат их хэрмийг “Барс хот-I”; Б. Түүнээс зүүнтэй 7 км зайтай байгаа Баруун Дөрөөгийн хэрмийг “Барс хот-II”; В. Барс хотоос зүүн тийш 15 кмт байгаа хэрмийг “Барс хот-III” гэв. Барс хот-I-ийн их хэрмийн хэмжээ нь хайш хайшаа 1600-1800 м, зузаан нь 4 м, одоогийн өндөр нь 1.5-2 м байна. Хэрмийн дотор ба зүүн талд нь 5 ба 7 давхар суваргатай байжээ. Хэрмийн баруун өмнөд хэсэгт өндөр шороон довжоон дээр чулуугаар барьсан бага хэрмийн ор байна. Тэр бага хэрмийн дотор 4 байшингийн суурьтай юм. Энэ бага хэрмийн орчин тойронд 5-6 м хэмжээтэй дөрвөлжин барилгын ор 10 гаруй байна...малтлагаар олдсон олдворууд нь бурхан шашны зүйл боловч, энэ “Барс хот”-ыг жинхэнэ хот цэргийн хуаран гэж үзвэл зохилтой”<sup>44</sup> гэсэн байна. Үүнээс үзвэл, энэхүү Барс хот нь Усхал хааны үед байгуулсан цэргийн бэхлэлт хот байх бүрэн магадлалтай юм.

Буйр нуурын газарт суусан Усхал хаан цэргийн жанждадаа зарлиг буулган Мин улсын хил хязгаарыг уулгалан довтлуулсаар байв. 1380 оны өвлийн дунд сард Их Юань улсын тэгшитгэн шийтгэгч сайд Өлзийбуха, Найрбуха нарын удирдсан цэрэг Юнпин-г довтлон Мин улсын дохигч түшмэл Люгуан-ыг алжээ. Гэтэл мянгатын захирагч Ванлү-гийн удирдсан цэрэг Их Юань улсын цэргийг

<sup>43</sup> Саган сэцэн. *Эрдэнийн товч*. Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар хийсэн. М.Баярсайхан. УБ., 2015. т. 155-157; Галдан. *Эрдэнийн эрих хэмээх түүх болой*. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Ж.Гэрэлбадрах. УБ., 2015.т. 144

<sup>44</sup> Пэрлээ Х. *Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон*. УБ., 1961.т. 62-66

бут цохиж, Өлзийбуха сайдыг олзлон авчээ.<sup>45</sup> 1381 оны хаврын тэргүүн сард Их Юань улсын тэгшитгэн шийтгэгч сайд Найрбуха нарын удирдсан цэрэг Мин улсын хил хязгаарыг довтлон түйвээжээ. Энэ үед Мин улсын хаан Жү Юаньжан зарлиг буулгаж их жанжин Сүда, зүүн, баруун гарын дэд жанжин Танхэ, Фү Юүдэ нараар их цэрэг захируулан Их Юань улсын цэргийг цохиулав. Мин улсын их цэрэг Умард Шар мөрөнд хүрэх үед Их Юань улсын цэрэг зугтан оджээ. Дэд жанжин Фү Юүдэ хөнгөн морьт цэргээр нэхэмжлэн хөөж Хүй шань уулын дэргэд Их Юань улсын цэрэгтэй тулалдан ялаад тэгшитгэн шийтгэгч сайд Билигбуха, тайш Вэньгун нарыг олзлон авчээ. Үүний дараа Мүин жанжин их цэргийг дайчлан мордож Молтош хаалгаар гарч Гао жоу, Сун жоу, Чуаннин чөлгөөгийн олон аймгийг дайлаад Люжү голыг гатлан хүрээлэнгийн мэдэгч Лисуань, түүний харьяат албатуудыг цөмийг олзлон авсан байна.<sup>46</sup>

Усхал хаан Буйр нуурын газарт суусан нь нэг талаар цэргийн хүчээ сэлбэж, хориглолт хамгаалалтаа сайжруулан бэхжүүлэхэд тохиромжтой, нөгөө талаар гадаад улс төрийн харилцаа холбоо тогтоож, цэргийн тусламж авахад хамгийн боломжтой газар нутаг нь байжээ. Тэрээр Ляодун-д 20 түмэн их цэргийг захиран сууж байсан Их Юань улсын сайд Нагачутай холбоо тогтоож, түүгээр дамжуулан Корйё улстай харилцаж, хамтын хүчээр Мин улсад цохилт өгч, Их Юань улсын Хятад дахь засаглал, ноёрхлыг сэргээн байгуулахыг зорьж байсан юм. Ийм учраас Мин улс Юань-Корйё улсын харилцаанд гол үүрэг гүйцэтгэж байсан Нагачугийн цэргийг 1387 онд бут цохин буулган авав. Үүний дараа Мин улс Буйр нуурын газарт төвлөрөн сууж байсан Усхал хааныг ганцаардуулан цохиж, эрхшээлдээ оруулан авахаар дахин их цэргээ хөдөлгөсөн юм.

1388 оны зуны дөрөвдүгээр сард Мин улсын хаан Жү Юаньжан-ы зарлигаар Ланьүй жанжнаар удирдуулсан их цэргийг дайчлан мордуулжээ. Түүний удирдсан их цэрэг Дайнин-гээс мордож Чин жоу-д хүрч ирээд Юань улсын хаан Төгстөмөр Буйр нуурт байгааг тагнан мэдээд замаа дөтлөн яаравчлан давшсан байна. Мин улсын их цэрэг Буйр нуураас дөч гаруй газарт орших Зуун худаг гэдэг газарт ирсэн боловч Их Юань улсын цэрэг харагдсангүй. Тиймээс Ланьүй цэргээ татан буцах гэтэл манлай жанжин Ванби түүнийг хориглон ятгажээ. Ингээд Ланьүй жанжны удирдсан их цэрэг давшин явсаар Юань улсын хаан Буйр нуурын зүүн талд наян газарт сууж байгааг тандан мэдэв. Тэр үед Юань улсын хаан, язгууртан ноёд сонор сэрэмжгүй байсны дээр хүчтэй салхи хөдлөн, шороогоор шууран харанхуйлсан учир Мин улсын их цэргийг довтлон ирснийг мэдсэнгүй. Гэнэт Мин улсын их цэрэг довтлон ирсэнд Их Юань улсын хаан, язгууртан ноёд ихэд сандран угтан байлдаад ялагджээ. Юань улсын тайвэй түшмэл Манзи Мин улсын цэргийг эсэргүүцэн тулалдаад алагдав. Энэ үед Юань улсын хаан Төгстөмөр, түүний хөвгүүн хунтайж Тянь Баонү, хүрээлэнгийн мэдэгч түшмэл Нэцэлэй, харилцан туслагч сайд Ширмэн зэрэг хүмүүс зугтан оджээ. Ланьүй шилдэг морьт цэргээр тэднийг нэхэмжлэн цохиж Юань улсын

<sup>45</sup> 《明史 (ming shi)》卷2, 本紀第2, 太祖2, 中華書局, 1974年, 第35頁。

<sup>46</sup> 谷應泰; 《明史紀事本末》卷10, 古元遺賓, 中華書局, 1977年, 141頁。

хааны удаах хөвгүүн Ди Баонү нарын 64 хүн, мөн хунтайж Билэгтийн сул хатад, гүнж зэрэг 59 хүнийг олзолсон байна. Мөн Зүүн ордны хэргийг хамт мэдэгч түшмэл Тойнтөмөр, У ван Дорж, Вай ван Дарма, тэгшитгэн шийтгэгч сайд Балан зэргийн 2994 хүн, цэрэг дайчид ба эрэгтэй, эмэгтэй иргэн 77037 хүнийг олзолжээ. Үүний зэрэгцээ хасбуу тамаг, зураг бичиг, алт мөнгөн тамга, гэрэгэ болон мал сүрэг, хөсөг тэрэг үлэмж ихээр олзлон авч, данслан бүртгээд буцжээ.<sup>47</sup> Ийнхүү 1388 оны Буйр нуурын тулалдаан Усхал хаан ялагдаж, их хохирол амссан байна.

Усхал хаан Төгстөмөр Буйр нуурын тулаанд Мин улсын цэрэгт цохигдон Хархорумын зүг зугтаж яваад Туул голын орчимд ирээд алагдсан билээ. Энэ тухай “Мингийн үнэн тэмдэглэл”-д “*Юань улсын Төгстөмөр хаан Буйр нуурт манай цэрэгт (Мин улсын цэрэг-Д.И) бут цохигдсоны дараа үлдсэн харьяат олныг дагуулан Хархорумын зүг зугтаж тэргүүлэгч сайд Яожү-г түшигэлсүгэй хэмээжээ. Тэндээс мордож Туул голд хүрч ирэх үед Есүдэрийн цэрэгт цохигдож, харьяат олон нь бутран сарнихад гагцхүү Төгстөмөр хаан Нэцэлэй нарын арван зургаан морьт цэрэгтэй зугтав. Замын зуур тэргүүлэгч сайд Яожү, тайвэй Мархаса нар 3 мянган цэрэг дайчлан угтахаар иржээ. Мөн тэндээс бас тайш Хөхтөмөрийн харьяат ард олон, хүлэг морь хүчтэй тул түүнийг түшиглэхээр санаархаж байжээ. Гэтэл тэнгэр хувьсаж гурван өдөр дараалан их цас орж Төгстөмөр хаан замд гарч чадалгүй саатжээ. Яг энэ үед Есүдэрийн томилсон Хорхудасан нарын түшмэд нэхэмжлэн ирж Төгстөмөр хааныг барин авч нумын хөвчөөр боож алжээ. Мөн түүний хунтайж Тянь Баонү-г хороожээ*”<sup>48</sup> хэмээжээ. Эндээс үзэхэд 1378 онд И ван Төгстөмөр Их Юань улсын хаан ширээг залгамжилсныг зарим нөлөө бүхий язгууртан ноёд эсэргүүцэж бослого үймээн дэгдээсэн бололтой. Үүнийг 1388 онд Аригбөхийн угсааны Есүдэр ноён Усхал хааныг барьж хороосон хэрэг явдал харуулж байна. Тэгэхээр Усхал хаан Хархорумаас Буйр нуурын газарт суусан нь Мин улсын цэргийн довтолгоонд цохигдсон хэрэг явдлаас гадна дотоодын зөрчил тэмцэл ч үүнд нөлөөлсөн байж болох юм.

Есүдэр ноён Усхал хаан Төгстөмөрийг барин авч нумын хөвчөөр боож алсан нь жирийн хэрэг явдал биш бололтой. Учир нь Чуанхэн-ий “Тогоонтөмөр хааны түүх” хэмээх сурвалжид “*Хуучны дүрмээр болбоос төрлийн ван их ялд унаваас нумын хөвчөөр боомилон алмуй. Үүнийг үхэл шагнах хэмээмүй*”<sup>49</sup> гэсэн байдаг. Тэгэхээр И ван Төгстөмөр Их Юань улсын хууль цааз, ёс уламжлалыг зөрчин хаан суусан учир Есүдэр ноён түүнд үхэл шагнасан бололтой. Бас энэ хэрэг явдал нь Аригбөх, Хубилайн угсааныхны хоорондох олон жилийн зөрчил тэмцэл, өш хонзонтой ч холбоотой байхыг үгүйсгэх аргагүй.

Эцэст нь дүгнэхэд, 1368 онд Их Юань улсын Хятад дахь засаглал, ноёрхол унаснаас биш Монголын төр улс мөхөөгүй юм. Өөрөөр хэлбэл, Монголын төр улсын харь улс орон дахь ноёрхол унаж, уугуул эх нутагтаа буцаж төвлөрсөн билээ. Энэ үед Их Юань улс бүрэн мөхөж, “Умард Юань” нэртэй шинэ улс

<sup>47</sup> 谷應泰：《明史紀事本末》卷10，古元遺賓，中華書局，1977年，144-145頁。

<sup>48</sup> 《明實錄 (ming shi lu)》卷194，洪武二十一年十月至十二月。

<sup>49</sup> Чуанхэн. *Тогоонтөмөр хааны түүх*. Үндэсний Хэвлэлийн Хороо, 2005. т. 69

байгуулагдаагүй гэсэн үг. Энэхүү “Умард Юань” гэдэг нэр бол улсын цол нэр биш, харин тухайн цаг үеийн Монголын улс төрийн төв умард газарт шилжиж, төвлөрөх болсон түүхэн хэрэг явдлыг түүхийн сурвалж бичгүүдэд онцлон тэмдэглэсэн ойлголт болно. Тухайн цаг үеийн Монголын төр улс нь “Их Юань хэмээх Их Монгол улс”-ын залгамжлал боловч ихээхэн хувирал, өөрчлөлт гарсан юм. Энэ нь улсын цол нэр хувиран өөрчлөгдөхөд нөлөөлжээ. Чингис хаан, Хубилай хааны үед Монголын төр улс хүчирхэгжин мандаж “Их” хэмээх улсын цолыг хэрэглэж байсан бол Билэгт хаан, Усхал хааны үед төр улсын сүр хүчин бууран доройтсон учир “Их” хэмээх улсын цол нэр гээгдэхэд хүрчээ. Харин “Юань” хэмээх улсын цол нэр нь уламжлагдан үлдэж, гадаад улс орнуудтай харилцах харилцаа, тусгаар тогтнолоо хамгаалан оршин тогтноход гол халхавч, хамгаалалт болсон байна. Их Юань улсын Тогоонтөмөр хаан, түүний залгамжлагчид Их Юань улсын Хятад дахь засаг захиргаа, ноёрхлыг дахин сэргээн байгуулахыг зорьж, 20 орчим жил идэвхтэй бодлого, үйл ажиллагааг явуулсан боловч эцсийн зорилгодоо хүрч чадаагүй билээ. Гэвч эдгээр хаадын бодлого, үйл ажиллагааны үр дүнд Хятадын Мин улсыг цэргийн довтолгоог бут цохиж, Монголын төр улсын тусгаар тогтнолыг батлан хамгаалж, өнө удаан жил оршин тогтнох үндэс суурийг тавьж өгсөн юм.

## **The authority and supremacy of the Yuan dynasty in China seek to be reinstated**

**D. Ider**

In 1368, the Mongolian state did not cease to exist solely due to the decline of the Yuan Dynasty's authority in China. Rather, the Mongolian state experienced a loss of its influence abroad and reverted to its homeland. At this juncture, the Yuan Dynasty had been entirely dismantled, and a new entity referred to as the “Northern Yuan” was not formally established. The term “Northern Yuan” serves not as a designation for a nation but as a concept highlighted in historical accounts, indicating that the political focus of Mongolia had shifted and consolidated in the northern region. The Mongolian state during this period was a continuation of the “Great Mongolia” known as the Great Yuan, albeit with considerable transformations and alterations that affected its nomenclature. Under the leadership of Chinggis Khaan and Kublai Khaan, the Mongolian state experienced significant growth and adopted the title of “Ikh.” However, during the reigns of Bilegt Khaan and Ushal Khaan, the state's power waned, leading to a reversion to the title “Ikh.” Nevertheless, the designation “Yuan” persisted, serving as a crucial means of maintaining diplomatic relations with foreign entities and safeguarding its sovereignty. Togoontumur Khaan of the Yuan Dynasty and his successors sought to restore the governance and supremacy of the Yuan Dynasty in China. Ultimately, due to the policies and actions of these rulers, the military incursions from the Ming Dynasty were repelled, ensuring the independence of the Mongolian state and establishing a foundation for its enduring existence.